

Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2019.12.12-ны өдрийн 10 дугаар хүралдааны шийдвэрээс:

10.1. “Уул уурхайн салбарын эрсдэлийн үнэлгээний нийтлэг заавар”-ын төслийн тухай хэлэлцээд Монгол Улсын Шадар сайдын тушаалын хавсралтаар батлуулахаар шийдвэрлэв.

10.2. Онцгой байдлын байгууллагын тактикийн таних тэмдгийг шинэчлэн батлуулах тухай хэлэлцээд Тагнуулын ерөнхий газраас санал авахаар тогтов.

10.3. “Гамшиг, аюулт үзэгдэл, ослын бүртгэл, гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээний захиргааны статистикийн мэдээллийн маягт, заавар”-ын төслийн тухай хэлэлцээд төслийг Үндэсний статистикийн хорооны аргазүйн зөвлөлөөр хэлэлцүүлэн, Шадар сайдад хүргүүлэхээр шийдвэрлэв.

10.4. “Нөөцийн бараа, материалын чанар, аюулгүй байдлыг хангах дотоод хяналтын журам”, “Журмыг хэрэгжүүлэх заавар”-ын төслийг батлуулах тухай хэлэлцээд журам, зааврын төслийг батлав.

10.5. Үндэсний аврах бригадын Уул уурхайн аврах ангид MNS ISO 45001-2018 стандартыг нэвтрүүлж буй ажлын явцын талаар танилцуулав.

10.6. “Онцгой байдлын алба хаагчдын бие хүний суурь судалгаа”-ны танилцуулгыг сонсов.

10.7. Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх зөвлөх мэргэжилтний багийн 2019 онд хийсэн ажлын тайланг танилцуулав.

10.8. Баруун бүсийн Онцгой байдлын байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн үйл ажиллагаанд явуулсан шалгалтын дүнгийн тухай танилцуулав.

10.9. Зүүн бүсийн Онцгой байдлын байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн үйл ажиллагаанд явуулсан шалгалтын дүнгийн тухай танилцуулав.

10.10. Өмнөд бүсийн Онцгой байдлын байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн үйл ажиллагаанд явуулсан шалгалтын дүнгийн тухай танилцуулав.

10.11. Хойд бүсийн Онцгой байдлын байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн үйл ажиллагаанд явуулсан шалгалтын дүнгийн тухай танилцуулав.

10.12. Улаанбаатар бүсийн Онцгой байдлын байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн үйл ажиллагаанд явуулсан шалгалтын дүнгийн тухай танилцуулав.

10.13. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн үйл ажиллагаанд явуулсан шалгалтын нэгдсэн дүнгийн тухай хэлэлцээд төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулах журамд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэв.

10.14. Онцгой байдлын байгууллагын 2019 оны тэргүүний хамт олон, оны шилдэг албан хаагчдыг шалгаруулах тухай хэлэлцээд Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/62 дугаар тушаалаар баталсан “Онцгой байдлын байгууллагын оны шилдгийг шалгаруулах журам”-д “Шилдэг аврагч-гал сөнөөгч”-өөр “5 алба хаагч” гэснийг “8 алба хаагч”, “Шилдэг ажилтан”-аар “1 алба хаагч” гэснийг “2 алба хаагч”, “Тэргүүний газар”-аар “1 газар” гэснийг “2 газар”, “Онцгой байдлын ерөнхий газрын даргын нэрэмжит шагналын санг 500,000 төгрөг” гэснийг “..... 1,000,000 төгрөг” гэж тус тус өөрчлөн, “Шилдэг Улсын нөөцийн ажилтан” гэсэн номинаци нэмж шинэчлэн батлав.

10.15. Онцгой байдлын байгууллагын 2019 оны онцгой гавъяа байгуулсан албан хаагчдыг шалгаруулах тухай танилцуулав.

---oOo---